



ЗӨВЛӨМЖ

#1. ЗӨВЛӨМЖ

Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор холбогдох хууль, журмыг боловсронгуй болгоход чиглэсэн санал санаачилгыг хэрэгжүүлэх, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1-д “Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулах”, мөн журмын 2.3-т “энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг нөөцөд байлгах”-аар тус тус заасныг аймаг, сумдад мөрдөхгүй байна. Тухайлбал, Аймаг 2017 онд Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэлгүйгээр, үлдэгдэлгүй захиран зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөсөн боловч зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах нийтлэг журам”-ыг баримтлаагүй шагнал урамшуулал, уралдаан тэмцээн, хүндэтгэл үзүүлэх зэрэг зориулалтын бус арга хэмжээнд зарцуулах зөрчлүүд давтагдсаар байна. Тухайлбал, Засаг даргын захирамжаар 2017 онд Нөөц хөрөнгийн 15,6 хувь буюу 50.891.900 төгрөгийг баяр наадамд, 14,5 хувь буюу 47.390.000 төгрөгийг шагнал урамшуулалд, 18,6 хувь буюу 60.798.750 төгрөгийг дэмжлэгт, 2018 онд 14,4 хувь буюу 32.020.000 төгрөгийг шагналд, 10,04 хувь буюу 24.001.790 төгрөгийг дэмжлэгт, 9,22 хувь буюу 22.422.000 төгрөгийг баяр наадамд, 2017 онд 19,9 хувь буюу 65.059.400 төгрөгийг, 2018 онд 26.664.000 төгрөгийг урамшуулал, тусламж, уралдаан тэмцээнд зарцуулжээ.



#1. ЗӨВЛӨМЖ

Тариалан сумын Засаг дарга 2017 оны 8 дугаар сард Хүнс, хөдөө аж ахуйн яамны ажлын хэсгийн гишүүдийн хоолны зардал, мөн оны 10 дугаар сард мониторингийн шалгалтаар ирсэн ажлын хэсгийн гишүүдийн хоол болон бусад үйл ажиллагааны зардлыг гаргаж, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулжээ.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2016 оны 415 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын хэрэгжилтүүд үр дүн муутай байна. Тухайлбал, худалдан авалтыг техник эдийн засгийн тооцоо үндэслэлгүйгээр төлөвлөдөг, төлөвлөсөн хугацаанд тендер зарлагдахгүй байх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын аргаас зайлсийж, харьцуулалтын болон шууд аргаар сонгон шалгаруулах, босго үнэд багтаан төлөвлөх, нэгтгэж нэг багц болгон төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой төсөл арга хэмжээг салган төлөвлөх, тендер шалгаруулалтад материалаа ирүүлээд Үнэлгээний хорооноос шаардлага хангахгүй дүгнэлт гаргаж, шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн ажилд захиалагч шаардлага хангаагүй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулдаг зөрчлүүд давтагдсаар байна.

Мөн ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссан байхад ажлын явц байдлыг бүрэн үнэлээгүй, гэрээний хугацаандаа ажлаа хийж гүйцэтгээгүй аж ахуй нэгжүүдэд гэрээний нөхцөлийн дагуу алданги тооцдоггүй зөрчил арилаагүй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017 оны 01, 2018 оны 01 дүгээр захирамжуудаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шатах тослох материалын худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хороог, аймгийн Засаг даргын 2017 оны А/106 дугаар захирамжаар аймгийн Бөхмөрөн сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй

#2. ЗӨВЛӨМЖ

Аймгийн тендерийн ажиллагааг хэлбэрээр санаачилгыг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагаанд холбогдох мөрдлөг болгох талаар заавар, хүргүүлэх, хороог заавал иргэний нийгмийн бүхий авлига, ашиг сонирхлын зөрчлөөс мэргэшсэн хаагчдаар тэдгээрийн байгууллага нэмэгдүүлэх, сургах, чадавхижуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.



#2. ЗӨВЛӨМЖ

“Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд тус сумын доройтсон газрыг нөхөн сэргээх, шилдэг туршлагыг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, 2017 оны 107 дугаар захирамжаар мөн төслийн хүрээнд Увс аймгийн газрын зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд экологийн бүс нутгийн үнэлгээний зөвлөмжийг тусган шинэчлэн боловсруулах, 2017 оны А/361 дүгээр захирамжаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө, аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, 2017 оны А369 дүгээр захирамжаар Бөхмөрөн сумын “Цагаан бураа чиглэлийн 10 квт-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, Улаангом сумын төв 11 дүгээр багийн ойн зурвас байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороодыг тус тус байгуулахдаа иргэний нийгмийн төлөөлөл оролцуулаагүй, мөн ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалт явуулах Үнэлгээний хороог 2017 онд аймгийн Засаг даргын 22 дугаар захирамжаар, 2018 онд 59 дүгээр захирамжаар тус тус байгуулахдаа бөгөөд Үнэлгээний хороодод хуульд заасан шалгуур хангаагүй албан хаагчдыг оруулсан байна.

Засаг даргын захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд нэгжийн дарга, тухайн нэгжийн мэргэжилтэн хамтдаа оролцож тендер шалгаруулалт явуулж байгаа нь бие даасан, хараат бус шийдвэр гарахад нөлөөлөх эрсдэл өндөртэй байна.



#3. ЗӨВЛӨМЖ

Худалдан авах ажиллагаанд техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв иж бүрэн хийгдсэн төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байх, хөрөнгийн эх үүсвэрийг бодитоор тооцсоны үндсэн дээр хуулиар тогтоосон хугацаанд төлөвлөн батлуулах, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд оруулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг оновчтой сонгох, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, шаардлагатай мэдээ мэдээллийг ил тод цахим хуудсанд байршуулах.

Автозам барилгын тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжид автозогсоол, замын тэмдэг, тэмдэглэгээг суурилуулах ажил гүйцэтгүүлсэн байна. Тухайлбал. “Могойн чуулган” ХХК, 2001.12.23-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдэж, талх нарийн боов, жимс, жимсгэнэ худалдаалах, аялал жуулчлал, хуурай замаар хийгдэх ачаа тээвэр, авто сэлбэгийн худалдааны чиглэлээр байгуулагдсан аймгийн Улаангом сумын 6 дугаар багийн 8 дугаар цэцэрлэгийн гадна автомашины зогсоол барих ажил гүйцэтгэх 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг, Улаангом сумын сургууль, цэцэрлэг орчмын бүсэд шинээр тэмдэг байрлуулах 10 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг тус тус гүйцэтгүүлэх гэрээ байгуулжээ. Ил гүүрийн засварын ажлын тендерийг зохион байгуулах Үнэлгээний хорооны гишүүд 3 гишүүн нь шаардлага хангаагүй үндэслэлээр “ССТ”-Од ХХК -ийг сонгон шалгаруулахыг татгалзсан байтал тусгай зөвшөөрөлгүй, төсөв нь буруу, тендерийн материал дутуу ирүүлсэн уг аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан байна.

Ажлын хэсгээс танилцсан 78 тендерийн 48 нь оролцогч байхгүй үндэслэлээр 1 аж ахуйн нэгж оролцуулж, гэрээ байгуулжээ. Энэ нь нийт худалдан авалтын 61,5 хувийг эзэлж байна. Үлдсэн 30 тендерийн 18-д нь 2 аж ахуйн нэгж оролцсоноос үзэхэд худалдан авах ажиллагаа зохих журмын дагуу явагдсан байдал эргэлзээтэй байна. Нөгөө талаас тендерийн техникийн шаардлагыг хэт өндөр тавих эсхүл тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд ач холбогдолгүй шаардлага тавих, төсөвт өртөг нь тухайн техникийн шаардлагатай нийцэхгүй зэргээс шалтгаалан аж ахуйн нэгжүүд оролцох оролцоо муу, тэдгээрээс тэгш оролцох боломжийг хязгаарлах үндэслэл болж байна.



#3. ЗӨВЛӨМЖ

Аймгийн “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд 102.800.000 төгрөгийн бүртгэлтэй 2010 онд үйлдвэрлэсэн 05-50 УВА улсын дугаартай Ланд круйзер-200 маркийн автомашины 6.600.000 төгрөгөөр дуудлага худалдаанд оруулсан гэх нэрээр өөрийн хамаарал бүхий этгээддээ худалдсан. Компанийн үндсэн хөрөнгөнд 107.560.120 төгрөгийн бүртгэлтэй 3 сунадаг авто краныг 6.400.000 төгрөгөөр зах зээлийн үнээс хэт доогуур тогтоож, дуудлага худалдаагаар худалдсан, тус компанийн гүйцэтгэх захирал нь өөрийн хувийн эзэмшлийн 81-67 УВХ улсын дугаартай 1995 онд үйлдвэрлэсэн HYUNDAI 5 TON TRUK маркийн Солонгос улсад үйлдвэрлэсэн жижиг оврын краныг өөрийн төрсөн дүүгийн найзын “Агь Гурван-Эрдэнэ” ХХК-нд шилжүүлж 97-15 ХОУ улсын дугаар шинээр авч “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Ховд аймаг дахь салбарт 47.950.000 төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ байгуулсан асуудлууд нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хуулийг зөрчсөн байж болзошгүй байна.



Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9.1-д “Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Олгосон зөвшөөрлийг үндэслэн сүм хийдийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.”, Концессын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10,2 дахь хэсэгт “Орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.”, Газрын тухай хуулийн 20.2.4-т “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн газрын нэгдмэл сангийн тайланг жил бүр хянан нэгтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, дээд шатны Засаг дарга, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах” гэж тус тус заасан.

Гэтэл дээрх хуулиудын холбогдох заалтуудыг зөрчин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 38 дугаар тогтоолоор “Сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах журам”-ыг, 2015 оны А/109 дүгээр тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж, 2018 оны А/07 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн тайлан хэлэлцэн баталсан байна. Аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах журмыг аймгийн ИТХТ-дийн 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсныг Төр, сүмийн харилцааны тухай хуулийн 9.1-дэх хэсгийг зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгуулах санал тавьж, 2018 оны 26 дугаар тогтоолоор хүчингүй болгууллаа.

#4. ЗӨВЛӨМЖ

Хуулиар эрх олгогдсоноос бусад этгээд дүрэм, журам батлах, хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй мөрдлөг болгох, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоох зэрэг зөрчлийг таслан зогсоох чиглэлээр аймаг, сумд, харьяа байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журамд мониторинг хийх, хууль тогтоомжид нийцүүлэх үүрэг, даалгавар хүргүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах.



Мөн Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар бүх шатны бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгогдсон “хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2014 оны А/107 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг баталж, уг журмын 6.5 дахь хэсгээр дуудлага худалдааны үнэ хаялцах хязгаарыг, 2014 оны 109 дүгээр тогтоолоор Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн төлбөрийн доод хэмжээг тус тус тогтоон одоог хүртэл мөрдлөгө болгож байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/347 дугаар захирамжаар баяр наадамд оролцох тээврийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийн үнийг суудлын автомашинд 3000 төгрөг, үйлчилгээний машин 5.000 төгрөгөөр тогтоож, “А” серийн зөвшөөрлийг 50 ширхэг, тусгай үйлчилгээний автомашин “Ү” серийн зөвшөөрөл 100 ширхэг, нийтийн тээврийн “В” зөвшөөрлийг 600 ширхэгийг, 2017 оны А/359 дүгээр захирамжаар суудлын автомашинд 5.000 төгрөг, үйлчилгээний машинд 10.000 төгрөгөөр тогтоон сери тус бүрийг 100-3.500 ширхэгийг, 2018 оны А/421 дүгээр захирамжаар суудлын автомашинд 3.000 төгрөг, үйлчилгээний автомашин 5.000 төгрөгөөр сери тус бүрийг 100-600 ширхэгийг хэвлүүлэн тээврийн хэрэгслийн жолооч нарт уг зөвшөөрлийг олгосон байна. Энэхүү тусгай зөвшөөрлийн хүрээнд ардын хувьсгалын 97 жилийн он баяр наадмаар иргэдээс үндэслэлгүйгээр **2.270.000** төгрөгийг хураасан байна.

#4. ЗӨВЛӨМЖ



Үндэсний баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т зааснаар аймаг, сумын Засаг дарга нь баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан зарцуулах эрхтэй ба Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолд зааснаар төсвөөс гарах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 сая, суманд 5.0 сая төгрөгөөр тогтоосон. Гэтэл тус аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас жишиг хэмжээг хэтрүүлэн баталсан байна. Тухайлбал, Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2017 оны 6/01 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадам тэмдэглэхэд 29.000.000 төгрөгөөр, 2018 онд 39.000.000 төгрөгөөр төсөвлөн аймгийн Засаг даргын Тамгын газарт эрх шилжүүлэн зарцуулжээ.

#5. ЗӨВЛӨМЖ

Төсвийн баяр тэмдэглэхдээ журам, баримталж, тохиолдолд гарах жишиг өөрчлөлт асуудлыг шийдвэрлүүлэх холбогдох тогтоомжийн зохион төсвийг, зарцуулахаас урьдчилан чиглэсэн авах.

хөрөнгөөр наадам, тогтоосон дүрмийг хэвшүүлэх, төсвөөс санхүүжилтийн хэмжээнд оруулах судлан замаар хууль дагуу байгуулах, үр ашиггүй урьдчилан сэргийлэхэд арга хэмжээ авах.



#6. ЗӨВЛӨМЖ

Газар олголтыг хуулийн дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр буюу дуудлага худалдаа явуулж, шийдвэрлэх.

Аймгийн Засаг даргаас аймгийн төвийн сум болох Улаангом сумын нутаг дэвсгэрт сумын Засаг даргаас санал авалгүйгээр иргэн хуулийн этгээдэд газар эзэмшүүлж байна.

Аймгийн төвийн цахилгаан дулааны шугам сүлжээ бүхий /аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газарт болох/ газарт аймгийн Засаг дарга захирамжаар газар эзэмшүүлж болох хэдий ч төвийн бүсэд хамаарахгүй газарт мөн аймгийн бусад сумдуудын төвд үйлчилгээний зориулалт бүхий газрыг тухайн шатны Засаг даргын саналыг авалгүйгээр, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг олгож байгаа нь Газрын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн.



#7. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> -ээс татаж үзэх).

Журмын 4.1-д “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-д заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасныг мөрдөж ажиллах шаардлагатай.



#8. ЗӨВЛӨМЖ

Аймгийн нийтийн томилогдохоор дэвшсэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухайн албан тушаалд томилохын өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажлыг зохион арга хэмжээ авах.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтан нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулсны дараа уг албан тушаалд томилох үүрэгтэй боловч нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулалгүйгээр томилдог зөрчил давтагдсан байна. **Тухайлбал, Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг** Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэд дарга болон Захиргаа хяналтын хэлтсийн даргыг тухайн албан тушаалд томилохдоо ХАСУМ хянуулаагүй томилсон нь АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байгаад дүгнэлт хийх нь зүйтэй (*Хавсралт 1*).



Төрийн албанд иргэнийг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ мерит зарчмыг удирдлага болгохгүй байна. Тухайлбал, Увс аймгийн Засаг даргын захирамжаар 23 албан тушаалтныг, Засаг даргын дэргэдэх байгууллагын даргын тушаалаар 5 байгууллагад 15 албан тушаалтныг төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт болон төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад ороогүй этгээдийг тус тус томилсон байна (*Хавсралт 2*).

#9. ЗӨВЛӨМЖ

Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсоны улмаас гарсан сул орон тоог нөхөх буюу удирдах албан тушаалд дэвшүүлэхдээ хуульд заасан үндсэн шалгуур, зарчим, журмыг баримтлах, энэ талаарх мэдээллийг иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбараар ил тод, нээлттэй болгох.



Төрийн мэргэшсэн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөх зөрчил арилахгүй байна. Тухайлбал, Увс аймгийн Засаг даргын Тамгын газраас 2017 онд 2, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 2018 онд 3 албан хаагчийг бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор шүүхийн шийдвэрээр эргэн томилогдсон нэр бүхий 5 албан хаагчид нийт **20.864.389** төгрөгийн нөхөн олговрыг олгосон байна (*Хавсралт 3*).

#10. ЗӨВЛӨМЖ

Төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас учирсан хохирлыг хууль бус шийдвэр гаргасан буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, төрийн жинхэнэ албан тушаалын томилгоонд хяналт тавих дээд шатны болон иргэд олон нийтийн хяналтыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх.



#11. ЗӨВЛӨМЖ

Удирдах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож буй үйлдлийг таслан зогсоох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийтийн албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга 2017 оны 09, 16, 68, 97 дугаар, 2018 оны 03 дугаар захирамжуудаар өөртөө үр дүнгийн урамшуулал олгох өөрийн хувийн ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэрүүд гаргасан байх ба энэ тохиолдолд Авлигын эсрэг хуулийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчилгүйгээ мэдэгдсэн мэдэгдэл, тайлбараа гаргаагүй байна. Аймгийн Хурлын дарга нь Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг үндэслэн аймгийн мэргэжилтнүүдэд тэтгэмжийн мөнгө 300 000 төгрөгийг олгохдоо өөрийн нэрийг оруулан шийдвэрлэсэн нь Улсын Их Хурлын 2017 оны 67 дугаар тогтоолын 1.1- дэх хэсэгт “2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300 000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох” гэж заасныг зөрчсөн асуудлыг өөрт нь танилцуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авлаа.

Мөн Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга Н.Ариунзаяа, сумын Засаг дарга С.Төгсболд, Засаг даргын Тамгын газрын дарга Н.Хадаахүү нар нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбар гаргалгүйгээр, дээд шатны албан тушаалтны бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр өөртөө урамшуулал олгосон байна.



Тус аймгийн Тариалан сумын Засаг дарга нь 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 25 дугаар албан бичгээр Хар тарвагатай ХХК-иас дөрвөн тэвш машины нүүрсний зөвшөөрөл, 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар албан бичгээр Хар тарвагатай ХХК-иас 300 л түлш, 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ЭС ТИ Жи ХХК-иас цэцэрлэгт хүрээлэн болон бусад газар засварлахад нийт 41 000 000 төгрөг, 2018 оны 2 дугаар 27-ны өдрийн 27 дугаар албан бичгээр Хар тарвагатай ХХК-иас Улаанбаатар хотод болох тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд 13,500,000 төгрөг, 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 48 дугаар албан бичгээр Хар тарвагатай ХХК-иас гэр оронгүй ам бүлд тусламж, хандив тус тус хүсч, удаа дараа санхүүгийн дэмжлэг авсан байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно гэж заасныг, 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэж заасныг тус тус зөрчсөн.

#12. ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтан авлигын эсрэг хууль тогтоомжоор хориглосон хандив, бэлэг авахтай холбоотой хязгаарлалтыг мөрдөж буй эсэхэд болон хуулиар зөвшөөрөгдсөн хандивыг дээд шатны байгууллага, албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлсэн, хандивлагчтай холбоотой 2 жилийн хугацаанд аливаа шийдвэр гаргасан зэрэгт тавих хяналтыг сайжруулах.